

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

## Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

### 1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 03 дугаар сард 1 удаа хуралдаж 4 асуудал хэлэлцэн 7 тогтоол баталлаа. Үүнд:

- Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын уран сайхны бодлого чиглэл, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэлэлцээд шаардлагатай боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, хөгжим зэмсэгийн шинэчлэл хийхэд шаардлагатай зардал төсвийг аймаг, орон нутгийн төсөвт үе шаттайгаар тусгах, холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар уран бүтээл туурвих нөхцөл боломжоор хангах, тус байгууллагын одоогийн бүтэц бүрэлдэхүүнд тулгуурлан өнөөгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөрвөх чадвартай хөгжимт жүжгийн театр болгох асуудлыг судлан холбогдох газарт тавьж шийдүүлэхийг аймгийн засаг дарга С.Бүрэнбатад, Уран бүтээлчдийн мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах, уран бүтээлийн төрөл хэлбэрийг өргөжүүлэх, урын санг баяжуулж мэргэжлийн түвшинд уран бүтээл туурвих, хөдөөгийн ард иргэдэд явуулын үйлчилгээ үзүүлэх, соёл урлагийн орчин нөхцөл, тохижилт үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийг “Сэлэнгийн долгио чуулга”-ын дарга Д.Уранбилэг нарт тус тус даалгалаа.

- Аймгийн Нэгдсэн эмнэлэгийг Баруунбүрэн сумын уугуул, Шинжлэх ухааны академич, анагаах ухааны доктор, профессор Базарын Дэмбэрэлийн нэрэмжит болгох шийдвэрийг гаргалаа.

- Мандал сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм” хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгалаа.

- Эрхэлсэн салбартаа хөдөлмөр бүтээлийн өндөр амжилт гаргасан Алтанбулаг сумын иргэн П.Гончигжавыг гавъяат тээвэрчин, Сайхан сумын иргэн Э.Багаабазарыг хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор, Сант сумын иргэн Г.Балжинням, О.Лхагвасүрэн, Ж.Цэрэндолгор, Сүхбаатар сумын ахмад настан Б.Хоролсүрэн нарыг Алтангадас одонгоор, Баянгол сумын ахмад настан Б.Баяраа, Ц.Сэвхээж нарыг хөдөлмөрийн хүндэт медалиар, тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

- Аймгийн хүн ардын эрүүл мэндийг сахин хамгаалах, өргөсөн тангарагаа нэр төртэй биелүүлж, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх үйлсэд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулан үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын иргэн Паньдгүнжийн Дашдэлэгийг, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулан үр бүтээлтэй ажилласан Орхон сумын ахмад настан Вандангийн Лхагважав нарыг тус тус Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

- Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Сэлэнгэ барилга захиалагч” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2014 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өглөө.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдад ажиллаж хурлын үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн туслалцаа үзүүллээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл Орхон, Орхонтуул, Сант, Сайхан, Баруунбүрэн сумдад ажиллаж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, 2014 онд зөвлөлөөс өгсөн заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр сум, байгууллага аж ахуй нэгжээс зохион байгуулсан ажлуудтай

танилцаж цаашид ямар ажил арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүллээ.

## **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

БНТУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Мурат Карагөз, TUMOSIAD-ийн салбарын хөрөнгө оруулагчдын хамт хоёр улсын эдийн засаг, соёлын салбарыг хөгжүүлэхэд чиглэгдсэн уулзалт хийх, Алтанбулагийн чөлөөт бүсийн үйл ажиллагаатай танилцах, Элчин сайдын яамны олон нийтэд нээлттэй дипломат ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймагт 2015 оны 03 сарын сарын 06-07-ны өдрүүдэд албан айлчлал хийлээ. Аймгийнхаа голлох бараа бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах, үйлдвэрлэлээ өргөжүүлэх, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлд гадаадын хөрөнгө оруулагчид, доноруудыг татахаар ажиллан, хамгийн анхны алхам болгож БНТУ-ын элчин сайдын яамтай хамтран ажиллаж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд Турк улсын ижил төстэй хотуудтай хамтын ажиллагааны санамж байгуулах тухай, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, аялал жуулчлалын чиглэлд хамтран ажиллахаар ярилцлаа.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас боловсрол, соёлын салбарт 2015 онд баримталж ажиллах бодлого чиглэлээ тодорхойлох, удирдах ажилтнуудыг чадвахижуулах зорилгоор “Сургууль, цэцэрлэгийг үр дүнтэй удирдах нь” сэдэвт сургалт, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын удирдах ажилтнуудтай гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 36 захирал, 39 эрхлэгч, 5 соёлын байгууллагуудын дарга, эрхлэгч, сумын Засаг даргатай гурвалсан гэрээг байгууллаа.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөв ойлголт өгөх, “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчилах, мэдээлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтанд шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч, тахарын албаны нийт 40 хүн хамрагдлаа.

Аймгийн “Нэг цонхны үйлчилгээний төв”-өөс аймгийн төв Сүхбаатар сумын алслагдсан багуудын иргэдэд нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулж, нэг цэгийн үйлчилгээгээр нийт 107 иргэн нийгмийн халамж, газар, улсын бүртгэл, нийгмийн даатгалын үйлчилгээг авлаа.

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн Газрын гишүүн, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат 2015 оны 03 сарын 12-14-ний өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллалаа. Тэрээр Алтанбулаг Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын иргэд хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн өнөөгийн байдалтай газар дээр нь танилцлаа.

Монгол Улсад шинэ үеийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 94 жилийн ой, Монгол цэргийн өдрийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, Сүхбаатар цэргийн хүрээний цэргийн болон цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд гар болон сагсан бөмбөг, ширээний теннис, үндэсний шагай харваа, тэргүүний дууч жагсаалч салаа, 9 мм-ийн ПМ гар буу, 7.62мм-ийн АКМ бууны буудлага, Марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах зэрэг 8 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж, байгууллагын нэгдсэн дүнгээр Хилийн 0243 дугаар анги тэргүүлж, 2015 оны Сүхбаатар цэргийн хүрээний шилдэг байгууллага өргөмжлөл, шилжин явах цомын эзэн боллоо.

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, БСШУ-ны сайд Л.Гантөмөр 2015 оны 03 сарын 19, 20-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллаж, Сант, Сайхан, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл

ажиллагаатай танилцаж, боловсролын салбарын багш нартай уулзалт зохион байгууллаа.

Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн газраас аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдад 2015 оны 03 сарын 23-27-ны өдрүүдэд Стратеги төлөвлөлт сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2015-2018 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсрууллаа.

Тус аймгийн Засаг дарга, Дархан-Уул аймгийн Засаг даргын хоорондын хамтран ажиллах гэрээний дагуу Дархан-Уул аймгийн Залуучууд театрын уран бүтээлчид 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдөр аймгийн “Сэлэнгийн долгио чуулга”-д уран бүтээлээ туурвилаа.

УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Барилга хот байгуулалтын сайд Б.Цогтбаатар, Гадаад харилцааны дэд сайд Н.Оюундарь, УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа, Эрүүл мэнд, спортын дэд сайд Д.Атармаа нарын бүрэлдэхүүнтэй баг Шаамар, Алтанбулаг, Сайхан, Сүхбаатар сумдын хаваржилт, тулгамдаж байгаа болон цаашид анхаарах асуудалтай танилцаж, иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгуулж, санал хүсэлтийг нь хүлээн авлаа.

#### **Бусад ажлын талаар:**

##### **1. Онцгой байдлын газар:**

Тайлант сард аймгийн Онцгой байдлын газраас 71 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 394 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 46, мэдэгдэл 11, хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 албан тушаалтныг 30000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ ногдууллаа.

2015 оны 03 сард 26.2 сая төгрөгийн хохиролтой 8 удаагийн объектын гал түймэр гарснаас 2 гал түймрийг иргэд унтраан, 6 гал түймэр дээр Аврах, гал унтраах анги ажиллалаа.

Гарсан 8 гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 6, мэргэжлийн шинжээчийн дүгнэлт 2-ийг үйлдэж, 2 гал түймрийн хэрэг мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны ашиглалтын буруугаас 2, пийшин, зуух, яндангийн цонолтоос 1, лаа, дэн, тамхи, шүдэнзний аажуу 3, шалтгаан тогтоогдоогүй 2 удаа тохиолдсон.

##### **2. Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдад “Хэмжилзүй өдөр тутмын амьдралд”, “Хүнс үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх нь”, “Стандарт гэж юу вэ?” сэдвээр мэдээлэл хийж, танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг зохион байгууллаа.

Алтанбулаг сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс “Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021:2007” стандарт, “Хүнсний бүтээгдэхүүний Эко тэмдэг болон зураасан кодны тухай” сургалт хийж, тохирлын үнэлгээ баталгаажуулалтын талаар мэдээлэл өглөө.

“Дэлхийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд “Эрүүл хүнс, эрүүл хооллолт” сэдвийн дор уулзалт ярилцлага зохион байгуулж, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Боловсрол соёлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Нэгдсэн эмнэлэг, “Алтан тариа” ХХК, Үжээд” ХХК-ийн төлөөлөл мэдээлэл хийж, хүнс үйлдвэрлэл, түүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлдвэрлэгч,

хэрэглэгч, төрийн байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хамтран ажиллах талаар санал солилцлоо.

“Дэлхийн ой, ус цаг уурын өдөр”-ийг тохиолдуулан “Ус ба тогтвортой хөгжил”, “Мэдлэгт тулгуурласан уур амьсгал” уриан дор аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний алба, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Ерөө голын сав газар, “Урсгал Ус” ХК хамтран өдөрлөг зохион байгуулж, ерөнхий боловсролын сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж, байгаль орчноо хайрлан хамгаалах, усыг хэмнэх талаар мэдээлэл өгч иргэн бүр үүргээ биелүүлэхэд санаачлагатай байхыг уриаллаа.

8 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, сумын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа үйлчилгээний газрынмөрдвөл зохих стандартын 84.0-өөс дээш хувийг хангасан 5 худалдаа, үйлчилгээний газарт, тохирлын гэрчилгээ олголоо.

Сайхан, Сүхбаатар сумын 7 аж ахуйн нэгж иргэний 9 нэрийн 23 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргаж ажиллалаа. Сүхбаатар сумын “Цаст Булган Хайрхан” ХХК-ийн үйл ажиллагаанд дотоодын бүтээгдэхүүний тохирлын үнэлгээ хийж, савлан үйлдвэрлэж буй мах, дайвар бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээнд хамруулан баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Сайхан сумын “Хөтөл Дээжис” цехийн бялуу, бялуун бүтээгдэхүүнд дотоодын тохирлын гэрчилгээ олгож, Хүдэр сумын иргэн Д.Нямаагийн үйлдвэрлэж буй гүзээлзгэнэ, гишүүгэний чанамал, Сүхбаатар сумын “Бэлчир” утсан загасны цехийн утсан загасны хаяг шошгонд “Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавих шаардлага MNS ISO 1:2007” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, холбогдох зөвлөмжийг өглөө.

“Тэс петролиум”, “Цемент шохой” ХХК, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газартай хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын гэрээ байгууллаа.

“ДСЦТС” ХК-тай хамтран Сүхбаатар сумын айл өрх, аж, ахуйн нэгж, байгууллагын төлбөр тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 321 ширхэг цахилгаан тоолуурыг баталгаажуулалтанд хамрууллаа.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

2-р сарын 28-ны байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	2079631,4	2140096,5	102,9
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	1728465,8	1497991,8	86,7
3	Орон нутгийн төсвийн зарлага	2079631,4	1643861,3	79,0
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	672120,5	521379,9	77,6
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	277138,2	307073,8	110,8
	Авто замын хөрөнгө оруулалт	36800,0	630,5	1,7
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1132073,0	1132073,0	100,0
5	Оёñû í ò° ñâ° ñ î ëã ñî í òóñãäé çî ðèóéàèòù í	7277061,1	7277061,1	100,0

	ø èèæççéúā			
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1002598,6	1002598,6	100,0
7	Засаг даргын нөөц	213300,0	77505,3	36,3

2015 оны төсвийн гүйцэтгэлийн 2 Үндэсний мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 102.9 хувь, улсаасавахсанхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 105.1 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 79.0 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 36.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2015 оны 2-р сар	2015 оны 3-р сар
<b>Нэг.Талх, гурил, будаа</b>				
1	Гурил /1-гурил/	1 кг	1200	1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	1000, 2200	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1800	1800
4	Элсэн чихэр	1 кг	1800	1800
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
<b>Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн</b>				
6	Хонины мах	1 кг	6800	6800
7	Үхрийн мах	1 кг	7500	7500
8	Адууны мах	1 кг	6200	6200
9	Ямааны мах	1 кг	6000	6000
10	Дотор мах цувдай	1 кг	5000	5000
11	Хиам, чанасан	1 кг	9500	9500
12	Гахайн мах	1кг	-	7000
<b>Гурав.Сүүн бүтээгдэхүүн</b>				
12	Сүү /задгай/	1л	1400	1400
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	1600	1600
15	Хорхой ааруул	1 кг	9000	9000
16	Айраг	1л	3500	3500
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	300	330
<b>Дөрөв. Бүх төрлийн өөх тос</b>				
19	Ургамлын тос	1 кг	1400	1400
20	Өөхөн тос	1 кг	2500	2500
21	Шар тос	1 кг	1600	1600
22	Масло /задгай/	1 кг	9000	9000
<b>Тав.Хүнсний ногоо</b>				
23	Төмс/Монгол/	1 кг	1500	1500
24	Лууван	1 кг	1500	1500
25	Манжин	1 кг	1500	1500
26	Байцаа	1 кг	1500	1500
27	Сонгино	1 кг	2000	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	3000	3000

29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3000	3000
31	Алаг салат /даршилсан/	ш	2500	2500
<b>Зургаа.Тээвэр шатахуун</b>				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

#### **1. Архивын талаар:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн архивын тасгаас “Шударга, ёс зүйтэй үйлчилгээ” аяныг зарлаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Төрийн архивт учирч болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, архивын сан хөмрөгийн баримтыг хамгаалах зорилгоор аймгийн Онцгой байдлын газартай хамтран гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

Төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх зорилгоор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Хушаат, Сант, Шаамар сумын Засаг даргын Тамгын газар, Түнхэл тосгоны захирагчийн алба, Сум дундын 20 дугаар шүүх, “Урсгал-Ус” ОНӨААТҮГ, Хүнс, хөдөө аж ахуйн газрын баримтуудыг цаасан буюу цахим хэлбэрээр хүлээж авах ажлыг зохион байгуулж байна.

Тайлант сард иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг Худалдаа бэлтгэлийн удирдах газрын баримтанд хийж шинэчилсэн дансны бүртгэл, устгах хэргийн актыг үйлдэн, Ардын боловсролын хэлтсийн хөмрөгийн 53 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийж, 11 баримтанд сэлбэн засалт хийлээ.

Мастер хувиас Photoshop програм ашиглан ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд Мод боловсруулах комбинатын 34 хадгаламжийн нэгжийн 7066 хуудас баримтаар ашиглалтын хувь үүсгэлээ.

Төрийн архивын AMS програмд Мод боловсруулах комбинатын 21 хадгаламжийн нэгжийн 3470 хуудас баримтыг шивж орууллаа. Үүнд: заалтын тоо 2683, хүний нэр14648, байгууллагын нэр 251, газар зүйн нэр247 байна.

Иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 196, цалингийн тодорхойлолт 5, магадлагаа 33, тодорхойлолт 19-ийг гаргаж үйлчиллээ.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Боловсролын чиглэлээр:**

Монгол Улсын Боловсролын Их сургуулиас мэргэжил сонголтын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор авч буй “Баримжаа” тестийг аймгийн нийт ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангийн сурагчид, ерөнхий авьяасыг шуурхай оношлох “Экспресс” тестийг багш болох сонирхолтой ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангийн сурагчдаас авч нэгтгэнхүргүүллээ.

Аймгийн Боловсрол, соёлын газраас “Кенгуру” олон улсын математикийн олимпиадыг 2015 оны 03 сарын 21-ний өдөр зохион байгуулж, нийт 24 сургуулийн 1071 сурагч оролцлоо.

Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшийн арга зүй, багшийг ажлын байран дээр нь тасралтгүй хөгжүүлэх зорилгоор 2015 оны 03 дугаар сарын 13,14-ны өдрүүдэд ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш нарын дунд “Бишгүүр хөгжмийг ноотоор тоглох аргазүй” сэдэвт сургалтыг аймгийн Боловсрол, соёлын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран зохион байгууллаа.

БСШУ-ын сайдын 2013 оны 309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ын дагуу чанарын үнэлгээний судалгааны шалгалтанд Сүхбаатар сумын 1,2,4 дүгээр сургууль, Ерөө сумын сургуулийн давхардсан тоогоор 1350 гаруй сурагчаас 11 шалгалтыг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгууллаа.

Боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг багш бүрт хүргэх, үзэл санааг хэрэгжүүлэх, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, авьяасыг нээн илрүүлэх, багшаар дамжуулан биеийн тамирын сургалтыг сайжруулах зорилгоор Боловсролын Хүрээлэнтэй хамтран аймгийн Боловсрол соёлын газраас 2015 оны 03 сарын 23, 24-нд биеийн тамирын багш нарын сургалтыг зохион байгуулж, нийт 56 багш хамрагдлаа.

## **2. Эрүүл мэнд, биеийн тамирын талаар:**

Аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг аймгийн Эрүүл мэндийн газраас Сайхан суманд 2015 оны 03 сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн удирдлагууд болон, аймгийн Нэгдсэн эмнэлэгийн зөвлөх эмч нар өрх, сум, тосгодын эрүүл мэндийн төвүүдийн дарга нар, хувийн хэвшлийн төлөөллүүд нийт 60 гаруй хүн оролцлоо.

Эрүүл мэндийн газарт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах ажлын хэсэг 2015 оны 03 сарын 09-ний өдөр хуралдаж аймгийн нэгдсэн эмнэлгийн 41 багц, Мандал суман дах нэгдсэн эмнэлгийн 37 багц, Хөтөл сум дундын эмнэлгийн 31 багцыг нийлүүлэх тендерийн тогтоол гарган холбогдох захиалагч болон эм ханган нийлүүлэх байгууллагуудад хүргүүллээ.

Аймгийн Эрүүл мэндийн газраас “Сувилахуйн хөгжил” сэдэвт онол дадлага хосолсон сургалтанд 10-н ээлжээр 2014 оны 12 сарын 20-оос 2015 оны 3 сарын 15-ыг дуустал нийт 180 гаруй сувилагчийг хамрууллаа.

2015оны 03 сарын 13-15-ны өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар суманд Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит өсвөр үеийн чөлөөт бөхийн олон хотын 37дахь удаагийн тэмцээнд Буриад улсын 4 баг Монгол Улсын 23 баг нийт 27 багийн 380 тамирчин 6 жинд 19 багц медалийн төлөө өрсөлдлөө.

## **3. Нийгмийн даатгалын талаар:**

2015 оны 03 сарын 20-ны байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өрөвчлөлт 6,1 тэрбум төгрөг байна. Үүнээс төсвийн газрын өрөвчлөлт 239.5 сая төгрөг, ажахуйн нэгжийн өрөвчлөлт 5948.9 сая төгрөг хүрээд байна. Өртэй 12 байгууллагад мэдэгдэл хүргүүлж, Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ, Үйлдвэрчний эвлэлийн Хороо, Шилмэлэсгий ХХК, Сэлэнгэ Оюу ХХК-ийн 254.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өрөвчлөлт шүүхэд өгч төлж барагдуулах тухай шүүхийн шийдвэр гаргаснийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлээд байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс өрөвчлөлт барагдуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласнаар 1.0 тэрбум төгрөгийн өрөвчлөлт барагдууллаа.

Засгийн газрын 52-р тогтоолындагуут этгэврийн нэмэгдлийг аймгийн хэмжээндхийлээ. Нийт 14377 этгэвэр авагчийн этгэвэр 356.6 сая төгрөг өөрнэмэгдлээ.

## **4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2015 оны 02 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 859 хүн байсан бол 178 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 35 ажлын байранд 31 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 63 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 943 боллоо.

Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагч нарт 3 дугаар сарын 05-ны өдөр Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, ажил

мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний хүрээнд тус хэлтсийн ахлах ангийн хүүхдүүдтэй эцэг, эхчүүдэд зориулан “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Барилгачдын холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл хамтран дэд бүтцийн салбарын хүрээнд “Хүний төлөө зөв тус” сэдэвт сарын аяныг өрнүүллээ.

Аж үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай хамтран 2012 оноос хойш Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан 8 аж ахуй нэгж, 6 иргэний ажлын байранд газар дээр нь танилцан зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа талаар хяналт шалгалт хийлээ.

#### **5. Хүүхэд залуучуудын талаар:**

“Хүүхэд нэг бүрийн эрхийг хамгаалах” зорилтын хүрээнд хүүхдийн талаар төрөөс баримталж буй бодлого, шийдвэр орон нутагт хэрхэн хэргэжиж байгаад, хүүхдийн өмнө тулгамждаж буй асуудлыг хамтран шийдвэрлэх зорилгоораймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс зөвлөн туслах баг Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар сумдадажиллалаа.

Тайлант сард аймгийн Нэгдсэн зөвлөлийн сурагчдыг оролцуулсан галт тэрэгний аяныг зохион байгууллаа.

2015 оны 01 сарын 24-ний өдөр Монгол Улсын гурван сая дахь иргэний чацуутнаар тодорсон Сэлэнгэ аймгийн харъяат 6 хүүхдийг алдаршуулах ажлыг зохион байгуулж, Хүүхдийн төлөө Үндэсний газраас ирүүлсэн гарын бэлэг, батламжийг гардууллаа.

#### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төвтэй хамтран тус сумын малчдын хаваржилт, мал төллөлтийн байдалтай 2015 оны 03 сарын 22-24-ны өдрүүдэд танилцах ажлыг зохион байгууллаа.

Энэ оны тариалалтанд шаардагдах улаанбуудайн үрийн судалгааг аж ахуйн нэгж, иргэд бүрээр нарийвчлан гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хүргүүллээ. Судалгаагаар аймгийн хэмжээнд 134.4 мянган га талбайд улаанбуудай тариалахад 21.5 мянган тн үр шаардлагатайгаас 18.0 мянган тн-ыг нөөцлөж, 1.1 мянган тн үрийн дутагдалтай байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Мөрөөдлийн цэцэрлэг” төрийн бус байгууллага хамтран, “Жимс жимсгэнэ, чимэглэлийн мод бут болон цэцгийн аж ахуй сонирхогчдод зориулсан сургалт семинар”-ыг зохион байгуулж, нийт 40 гаруй ногоочдыг оролцуулан гарын авлага материалаар ханган мэдээллээр хангалаа.

Аймгийн хэмжээнд 678227 толгой эх мал төллөхөөс энэ сарын 23-ны байдлаар 81650 толгой эх мал төллөж, мал төллөлт 12 хувьтай байна. Үүнээс: ингэ38, гүү159, үнээ5197, эм хонь48663, эм ямаа27924 мал төллөсөн төл бойжилт 100 хувьтай мал жилбэ сайтай мал төллөлт хэвийн, төллөлтийг урьд оны мөн үетэй харьцуулбал мал төллөлт 25797 толгой малаар илүү төллөсөн үзүүлэлттэй байна. Том малын зүй бус хорогдол аймгийн хэмжээнд 619 толгой мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үетэй харьцуулахад бага зэрэг өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн тэжээлийн нөөцөд 90 тонн хивэг, 5000 боодол өнжсөн өвс байгаагаас малчин мал бүхий иргэдэд хөнгөлөлттэй үнээр зарж энэ сарын байдлаар 15.2 тонн хивэг, 370 боодол буюу 7.4 тонн өвс борлуулаад байна.

#### **Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:**

##### **1. Газрын харилцааны талаар:**





мод бэлтгэх хуваарь олгохгүй байх талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нартай хамтран ажиллаж байна.

Сэлэнгэ мөрөн, Зэлтэр гол битүү мөсөн бүрхүүл харзтай, Орхон, Хараа, Ерөө, Хүдэр голууд битүү мөсөн бүрхүүл тогтсон байна. Мөсний зузааны хувьд Сэлэнгэ мөрөн Зүүнбүрэн сум орчим 90 см, Сүхбаатар сум орчим хэмжих боломжгүй, Орхон гол Сүхбаатар сум орчим 95 см, Орхон сум орчим 91 см, Ерөө гол Ерөө сум орчим 72 см, Дулаанхан тосгоны орчим 80 см, Хараа гол Баянгол сум орчим 60 см, Хүдэр гол 22 см, Зэлтэр гол 37 см зузаантай байна. Мөсний зузаан өнгөрсөн арав хоногийн хугацаанд 3-20 см-ээр нимгэрсэн байна. Олон жилийн дундажтай харьцуулвал Сэлэнгэмөрөн, Ерөө, Зэлтэр, Хүдэр голууд 4-27 см-ээр нимгэн, Хараа, Орхон голууд 1-5 см зузаан байна.\

### **Долоо.Сум орон нутгийн талаар:**

#### **1.Баянгол сум:**

Тус сумын хэмжээнд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчлсан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогч хүүхдэд эрүүл мэнд, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зорилгоор удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах, үр дүнг тооцох хамтарсан багийн бүрэлдэхүүнийг байгууллаа.

Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 07 тоот тогтоолоор сумын Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааг зохион байгуулж, 1-р байрт ерөнхий боловсролын сургууль, удаах байрандэрүүл мэндийн төвийг тус тус шалгарууллаа.

Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж аюулгүй газар шилжин байрших дадлага сургуулийг зохион байгуулахаар Онцгой байдлын харъяа гал унтраах 40-р ангитай хамтран нийт төр төсвийн байгууллагын 72 алба хаагчдыг сургалтанд, хамруулж сумын Засаг даргын 2015 оны А/29 тоот захирамжаар Иргэний хамгаалалтын штаб, алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгууллаа.

Аймгийн засаг даргын 2014 оны А/380 тоот “Эх хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шинэчилсэн судалгааг гаргалаа.

#### **2.Баруунбүрэн сум:**

Аймгаас 2015 оныг “Иргэн таны төлөө” жил болгон зарласантай холбогдуулж сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2015 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг сумын төвийн 120 айл өрх сумын Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдаасасуумжийн хуудсаа санал асуулга аван иргэдийн саналыг хүлээн авлаа.

Тус сумын байгаль хамгаалагчид, багийн Засаг дарга нар хог хаягдлыг бууруулах талаар “Хог хаягдлын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төсөлд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн саналыг авч, хатуу хучилттай зам дагуух хогийг цэвэрлэж, сумын төвийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж айл өрх, албан байгууллагуудыг татан оролцууллаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумын Засаг даргын Тамгын газраас хамтран сумын “Бүрэндулаан” халаалтын төв “Шинэ Орос хийц” Ойн мэргэжлийн байгууллага болон ШТС-уудад хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, цаашид анхаарах асуудлын талаар “Зөвлөн туслах үйлчилгээ”-г үзүүллээ.

#### **3.Жавхлант сум:**

Тус сумын идэвхтэй Өмнөд аймаг Хөдөөний үүсгэлд 10 аюулгүй байдлыг 2015 ийн 03 сарын 13-ийн өдөр хуралдаж, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг 2012-2016 ийн үзүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжилт,

сoй uй 2015 ий u дo нaгeй oй ай oдaй e, "Noi o aaxuyõ nai" -aан i eã õ cyyeeeyi -eayey, õyi ayuy, õzãø eyeyi õi õiõ õõõae, Aaeãeü i õ-i u õyi aeõu i aeãai u 2014 ий u õaeeyai, õãããããeyi aeãai u 2014 ий u õaeeyai, cõй uй иргeдийн Oлoөлөгчдийн Oурлуи 2014 ий u õaeeyai õõõ õõõ õyeyeyey.

Тайлант сард Сумын хүүхдийн Цэцэрлэг "Эцэг эхчүүдэд зөвлөх нь" сэдэвт нoдãeõeeyi зохион байгуулж нийт 40 ãõõe aeãai õãã, AãÐA I ei Oeyüi байгууллагаас "Хоршооны тухай" сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 19 албан õãã, Спортын мастер Д.Ганбаатарын нэрэмжит "Би эр хүн" кросс гүйлтийн тэмцээнi çi õei aeãõõeãããe eõõ 80 ãõõe eõãyi i õi eõлоо.

"Авьяас" дэд хөтөлбөрийн хүрээнд Хүүхэд нэг бүрийн авьяасыг нээн илрүүлэх зорилгоор "Эх орон эндээс эхэлдэг" анги нийтээрээ унших шүлгийн уралдааныг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ахмадын хороотой хамтран ерөнхий боловсрол сургуулийн сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа.

#### **4.Зүүнбүрэн сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Зүүнбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй Полисан ХХК-ийндулааны цахилгаан станц, хэсгийн халаалттай зуух, нам даралтын зуухны байгаль орчны нөлөөлөх байдалд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, "Их эрсдэлтэй" гарсан тул илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, Монгол Улсын агаарын тухай хуулийн дагуу 1.728 мянган төгрөгөөр торголоо.

Зүүнбүрэн суманд 73310 толгой мал өвөлжиж байгаагаас 34707 толгой малд 15560 тн өвс, 36370 тн хүчит тэжээл шаардлагатай байгаа судалгааг гарган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

Сумын хэмжээнд нийт 35308 хээлтэгч мал байгаагаас 5398 нь төллөж, мал төллөлт 15.2 хувьтай байна.

#### **5.I ai aeõ noi :**

Олон Улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан тус сумын Засаг даргын Тамгын газар, Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Хараагийн бүсийн эмэгтэйчүүдийн дунд "99 сарнай" баярын цэнгүүн зохион байгууллаа. Цэнгүүний үеэр Хараагийн бүсийн шилдэг ээжүүдийг тодруулан шагнаж, 99 ээжид Монгол хатдын өргөмжлөл, хүрэлцэн ирсэн бүх ээжүүддээ сарнай цэцэг, дурсамжийн хамт гардуулан "Мөнгөн хараа"дуу бүжгийн чуулгын тоглолт, "Цэн тогоруу" уран сайхны киногоор бэлэг барилаа.

Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийг тохиолдуулан "Сүрьеэ өвчин болон түүнийг тойрсон тулгамдсан асуудлуудын талаар мэдээлэл өгөх, мэдлэгийг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зааварчилгаа өгөх, сүрьеэ өвчинтэй тэмцэхэд олон нийтийн оролцооны ач холбогдол, сүрьеэ өвчтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах байдлыг бууруулах талаар сурталчлах зорилгоор сумын Эрүүл мэндийн төвөөс 8000 метрийн Марафон гүйлтийн тэмцээнийг зохион байгуулж, нийт 300 гаруй тамирчид өрсөлдлөө.

Аймгийн Боловсрол, соёлын газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран аймгийн ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудын"Удирдлагын оролцоо-Сургалтын чанарт"сэдэвт сургалтыг Мандал суманд зохион байгууллаа.

#### **6.Орхон сум:**

Тус сумын Засаг даргын 2013 оны А/28 тоот захирамжаар 14 хоногт нийт сумын нийт төр төсвийн байгууллагуудын мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулж байна. Тайлант сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 141 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар" хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах, мэдээ мэдээллээр хангах зорилгоор 2015 оны 3 сарын 18-ны өдөр төрийн албан хаагчдын мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулж, нийт 90 гаруй төрийн албан хаагч оролцлоо. Тус арга хэмжээнийн хүрээнд сумын Засаг

даргын Тамгын газраас “Хүнсний ногоо” аймгийн дэд хөтөлбөр, “Чацаргана” аймгийн дэд хөтөлбөр, “Сүү” үндэсний хөтөлбөр, Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр, “Ногоон Сэлэнгэ” аймгийн дэд хөтөлбөр, “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Ус” хөтөлбөр, “Ойн дэд хөтөлбөр”-ийг тус тус танилцууллаа.

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл иргэдэд хүрч буй эсэхэд “Та үүнийг мэдэх үү” асуумжийн хуудсаар санал асуулгыг 90 гаруй иргэдээс авч дүгнэлээ. Санал асуулгын дүнгээр оролцсон иргэдийн 72.5 хувь нь хангалттай үнэлгээг өгч, 27.5 хувь нь хангалтгүй гэсэн үнэлгээг өглөө.

Сум, орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, манлайллыг идэвхжүүлэх, эрчимжүүлэх замаар сумын хөгжлийг түргэтгэх зорилгоор “Сумын хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо” чуулга уулзалтыг 2015 оны 03 сарын 06-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Чуулганд нийт 180 гаруй эмэгтэйчүүд оролцож, Орхон сумын эмэгтэйчүүдэд хандсан уриалга гаргалаа.

#### **7.Орхонтуул сум:**

Сумын Засаг даргын Тамгын газраас удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг 2015 оны 03 сарын 04-ний өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд төр төсвийн байгууллагуудын удирдах ажилтнууд болон Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид нийт 30 гаруй хүн оролцож, 2014 онд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, алдаа оноогоо тодотгож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Зөвлөгөөнөөс төрийн албан хаагчдын үйл ажиллагааны чанар, өгөөжийг сайжруулахаар иргэдийн санал санаачлагыг тогтмол авч, үйл ажиллагаандаа тусгах, мэдээллэх, байгууллагуудынхаа үйл ажиллагаанд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, хэрэглэгчийн үнэлгээг авах ажлыг тогтмол зохион байгуулж байх зөвлөмж гарган багийн Засаг дарга нар, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд, цагдаагийн албаны ажилтан албан хаагчдад хүргүүлээ.

Сумын Засаг даргын 2015 оны А/14 тоот Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах захирамжаар Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах ажлыг хэсгийг байгуулан, удирдамж, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хаврын хуурайшилт эхэлж ой хээрийн түймрийн аюултай үе эхэлж байгаатай холбогдуулан сумын хэмжээнд ой хааж, ойн сан бүхий газруудад аялал зугаалга хийх, мод бэлтгэх бусад үйл ажиллагаа явуулахыг хориглон зогсоогоод байна.

#### **8.Сант сум:**

Сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оны 3-р сарын 06-ны өдөр “Малчдын зөвлөлгөөн”-ийг зохион байгуулж, сумын мал аж ахуйн салбарын 2014 оны үр дүн, цаашид баримтлан ажиллах бодлого чиглэл, “Бошгын булаг” мал эмнэлэг үржлийн нэгжийн 2014 онд хийсэн ажлын тайлан, “Хүнсний аюулгүй байдал”, “Бэлчээрийн сэлгээ хийх нь” цахим хичээл, “Шилмэл мал-2014” улсын үзэсгэлэн худалдааны фото мэдээлэл, “Улсын сайн малчин шалгаруулах журам”, “Сайн дурын даатгалын ач холбогдол”, “ЭМД-ын тусламж үйлчилгээний зардлын тухай”, “Байгаль хамгаалалд малчдын оролцоо”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” сэдвүүдээр мэдээлэл өглөө. Зөвлөлгөөнд нийт 97 малчин оролцлоо.

Сант сумын “Төлчин эмэгтэйчүүдийн уулзалт өдөрлөг”-ийг 2015 ны 03 сарын 09-ний өдөр зохион байгуулж, нийт 45 төлчин эмэгтэйчүүд хамрагдан, эрүүл мэндийн төвийн эрхлэгч “Нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвээр илтгэл мэдээлэл хийлээ. Уулзалтын үеэр эрүүл мэндийн үзлэг, караоке тэмцээн, танилцах үдэшлэг зэрэг арга хэмжээ явагдаж мал аж ахуйн салбарт олон жил үр

бүтээлтэй ажилласан малчин Д.Бадамхорол, А.Урангоо нарыг аймгийн Засаг даргын жуух бичгээр, И.Чагцалмаа, Ч.Жигдэн, Б.Хүрэлмаа нарыг сумын Засаг даргын жуух бичгээр тус тус шагнаж урамшууллаа.

Сумын Засаг даргын 2015 оны А/23 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2015 оны 03 сарын 16-ны өдөр худалдаа үйлчилгээний 3 нэгж талбар, үйлдвэрлэл үйлчилгээний 2 нэгж талбар нийт 5 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгууллаа.

“ADRA” олон улсын байгууллагаас тус суманд хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх төслийн хүрээнд, “Хоршооны тухай ойлголт”, “Хүлэмжийн тариалалтын тухай” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, нийт 43 иргэн хамрагдлаа.

#### **9. Сүхбаатар сум:**

Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам, 340 дүгээр тогтоолоор баталсан Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журмыг хэрэгжүүлэх, дадлага сургалтыг зохион байгуулах төлөвлөгөөг Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд танилцуулах, дадлага сургалтын бэлтгэл байдлыг хангах, сургалтын үеэр хэрэгжүүлэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулах зэрэг зөвлөгөө зөвлөмжийг өгөх зорилго бүхий сургалтыг аймгийн Онцгой байдлын газар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2015 оны 03 сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан “Бид-нэг сумынхан” сайн үйлсийн аяныг зохион байгуулж, Монгол гэр бүлийн үнэ цэнэ, бат бэх байдал, нийгэм, эдийн засаг дахь гэр бүлийн оролцоог нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт лекцийг “Зөв амьдралын хөтөч” ТББ-тай хамтран зохион байгуулж нийт 300 иргэн хамрагдлаа.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Хог хаягдлын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулж, Хог хаягдлын тухай хуулийн хүрээнд сургалт, сурталчилгаа явууллаа.

Ардын дууны өв сангаас хүүхэд багачуудыг суралцахад дэмжлэг үзүүлэх, тэдний авьяасыг хөгжүүлэх “Авьяас” хөтөлбөр, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах монголын уламжлалт зан үйлийг иргэд хүүхдүүдэд төлөвшүүлэх зорилгоор сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Дуулах өв-2015” уралдааныг зохион байгууллаа.

#### **10. Алтанбулаг сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэгтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, гарын авлагаар хангаж ажиллалаа.

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар хамтран нийтийн хоолны газрын худалдагч, тогооч нарт “Стандарт, эрүүл ахуй”-н сургалтыг зохион байгууллаа.

Тайлант сард сум дундын 20-р шүүхээс “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулж, Шүүхийн шинэчлэлтэй холбоотой шинээр батлагдсан багц хуулийн талаар мэдээлэл өгч, мөн “Сэлэнгэ амьдрах сайхан” төрийн бус байгууллагаас “Архины хор нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг хийлээ.

#### **11. Цагааннуур сум:**

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраасаа адоёи íýæ áæææææææíí ööææææææ 2 óààà çí öeíí áæææææææ öàā çæeéí ì ýáýýeýe ° æí сумын соёлын төвийн çéè ææææææææææ öàì eèöeàà.

2015 оны 02 сарын 27-28-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Буган халиун ажнай морин спорт уяачдын холбоо, хангайн бүсийн хаврын морин уралдаан зохион

байгуулах комиссоос Цагааннуур сумын Улаан худаг гэх газар “Сэлэнгэ хурд 2015” хангайн бүсийн хаврын морин уралдаан зохион байгуулагдлаа.

2015 оны 03 сарын 17-ны өдөр Тус сумын Засаг даргын Тамгын газар, сумын залуучуудын холбоотой хамтран сумын залуучуудын чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулга уулзалтаар сумын Засаг дарга залуучуудын талаар баримтлах бодлого чиглэлийн талаар, сумын залуучуудын холбооноос өнгөрсөн онуудад хийсэн ажлын тайланг тус тус танилцуулан, ерхийн үйлдвэрлэл эрхэлж амжилттай ажиллаж, хөдөлмөрлөж байгаа 3 залууг шагнаж урамшуулан, сумын залуучуудын холбоог шинэчлэн зохион байгуулж тэргүүлэгчдээ сонголоо.

#### **12.Хушаат сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Иргэдтэй хийх уулзалт” арга хэмжээг зохион байгуулж, сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, суманд зохион байгуулагдаж байгаа болон цаашид зохион байгуулагдах ажил, арга хэмжээнүүдийн талаар, ойн мэргэжлийн ангиудын тайлан, газар зохион байгуулалтын талаар мэдээллүүдийг иргэдэд хүргэлээ.

2015 онд хийгдэх Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилтийн тодотголыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж 2014 оны орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт дутуу 3 ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлээ.

Хушаат сумын хэтийн хөгжлийн төлөвлөгөө, хот байгуулалтын зураглалын ажлын гүйцэтгэлийн эхний шатны тайланг төрийн албан хаагчдад танилцуулж, анхан шатны хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Цас ихтэй хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газраас Дархан-Уул аймгийн МайндТэйч ХХК-тай газар тариалангийн үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагын үүднээс гэрээ байгуулан 3 тнрапсны шахдас, хүчит уургийн тэжээлийг малчид, мал бүхий иргэдэд эргэн төлөх нөхцөлтэйгээр олгох ажлыг зохион байгуулж байна.

#### **13.Хүдэр сум:**

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын Тамгын газраас “Ойн тухай хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөө” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, 33 иргэн хамрагдлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай сумын Засаг даргын 2015 оны А/03 тоот сумын Засаг даргын захирамжаар хэв журам сахиулах үүрэг бүхий олон нийтийн эргүүлээр 2 иргэнийг томилж сар бүр 350.0 мянган төгрөгөөр цалинжуулж 180.0 мянган төгрөгийн хувцас хэрэгсэлээр хангалаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Сэтгэц наркологийн хүрээлэнд санал тавьж, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэргэлдэг иргэдэд “Архи амьдралын дайсан” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Засаг даргын нөөц хөрөнгөөс 2500,0 мянган төгрөгийг гарган 10 иргэнийг архины эмчилгээнд хамрууллаа.

#### **14.Шаамар сум:**

Тус суманд ажиллаж амьдарч буй төрийн албаны тэргүүний ажилтан ахмад настан Т.Ганбаатарын санаачлагаар сумыг Соёлын төвөөс төсвийн байгууллагуудын дунд “Спиртлэг биш-Спортлог амьдаръя” уриан дор холимог гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж сум, тосгоны 16 багийн 130 гаруй ажилтан албан хаагчид оролцож, тэргүүн байрыг сумын ерөнхий боловсролын сургуулийн баг, дэд байрыг сумын Засаг даргын Тамгын газрын баг, гуравдугаар байрыг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн багууд тус тус эзэллээ.

Шаамар сумын иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу нийтийн хоолны газруудад ихээхэн хэмжээгээр амьдарч байсан эзэнгүй золбин нохойг устгах асуудлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, байгаль орчны сангаас хэмнэгдсэн төсвөөс тодотгож суманд 150, тосгонд 100 нохойг устгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, 03 сарын 20-23-ны өдрүүдэд гүйцэтгүүлээ.

Тайлант сард Ойн хууль, Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал, усны тухай хуулийн хэрэгжилтэнд нийт 5 удаагийн хяналт шалгалтыг хийж, зөрчил гаргасан 4 иргэнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 2 зөрчлийг гарилгуулах талаар хугацаатай албан шаардлага өглөө.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР